ЗАХИАЛАГЧ:
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗАСАГ ДАРГА А.ЭРДЭНЭСАЙХАН

ГҮЙЦЭТГЭГЧ:
"ШҮРЭН ТИТЭМ" ХХК-НЫ
ЗАХИРАЛ П.БАЯРСАЙХАН

# ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН "1-Р БАГИЙН БАРИЛГЫН ЗУРАГ ТӨСӨВ" - ИЙН АЖЛЫН ГЭРЭЭ ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202304020

2023 оны 05 дугаар сарын 01 Хараат

Нэг талаас (цаашид "Захиалагч" гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас "Шүрэн титэм" ХХК-ны захирал П.Баярсайхан (цаашид "Гүйцэтгэгч"гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 01 –ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын "1-р багийн барилгын зураг төсөв"-ийн ажлыг ДУГАЦДСЗДТГ/202304020 дугаартай (цаашид "гэрээний үүрэг" гэх) 16,000.000 (Арван зургаан сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь "1-р багийн барилгын зураг төсөв" -ийн ажлын 16,000,000 (Арван зургаан сая ) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.

4. Гүйцэтгэгч нь тус сумын "1-р багийн барилгын зураг төсөв"- ийн ажлыг заагдсан нөхцлийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр эхлүүлж 2023 оны 05 дугаар сарын 15 -ны өдрийн дотор чанартай хийж гүйцэтгэнэ.

5. Санхүүжилтийг ажлын гүйцэтгэл дууссаны дараа ажлын 5 хоногийн дотор 100% олгоно.

6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;

6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;

6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;

6.4 Гэрээний тусгай нөхцөл;

6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;

6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт

6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь

6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

11. Зураг төслийн ажлыг барилгын зураг төсөл зохиоход мөрдөж буй норм, дүрэм бусад холбогдох техникийн баримт бичгийн дагуу чанартай боловсруулан гэрээт хугацаанд хүлээлгэн өгөх ба хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээснээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

12. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
БАГИЙН ЗАСАГ ДАРГА
........................ Г.ЖАРГАЛМАА

**ХАЯГ:** Дундговь аймгийн Цагаандэлгэр

**Утас:** 88215691

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
"ШҮРЭН ТИТЭМ" ХХК-ЫГ
ТӨЛӨӨЛЖ
........................ П.БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ
ШҮРЭН ТИТЭМ
ХХК

**ХАЯГ:** Улаанбаатар хот, Хан-Уул Дүүрэг, 4-р хороо, ВИВА Сити N-18-2

**Харилцах банк:** Голомт Банк

**Регистрийн дугаар: 5163757**

**Утас: 99907191**